



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Иргэний эрх зүйн маргаан<sup>1</sup>)

### ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ТӨЛБӨР ТӨЛӨХ ВАЛЮТЫН ХАНШИЙГ АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ БАТАЛГААЖУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГАРСАН ӨДРӨӨР ТОГТООХ НЬ ЗҮЙТЭЙ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 001/ХТ2026/00087

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2026 оны 04 сарын 14-ний өдөр

**Шийдвэрийн төлөв:** Хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгон, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.

#### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Дани Улсын нийтийн өмчит “И” ХХК нь Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт холбогдуулан Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн ... дугаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсон тухай тогтоолыг хүчингүй болгуулах, ... бүртгэлийн дугаартай шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулахыг хариуцагчид даалгах тухай нэхэмжлэл гаргасныг хариуцагч эс зөвшөөрч маргажээ. Нэхэмжлэлийн үндэслэлээ “... Германы арбитрын институтын шийдвэрээр “М” ХХК-аас 85,350,466.8 доллар болон 856,570.33 еврог тус тус гаргуулж, нэхэмжлэгч “И” ХХК-д олгохоор шийдвэрлэсэн. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар арбитрын шийдвэрийг баталгаажуулж, гүйцэтгэх хуудас бичигдэж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлүүлсэн. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч “М” ХХК нь нийт 246,517,008,635 төгрөг төлснийг Нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх газраас гадаад гуйвуулгаар нийт 72,925,260.49 ам.долларыг шилжүүлж, шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью-Йоркийн Конвенцын 3, 5 (1) е, 5 (2) b нь арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх эцсийн шийдвэр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд **гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн ихэнх улс орнууд шийдвэрт заасан төлбөрийг валютаар төлдөг нь нэгэнт олон улсын арбитрад хүлээн зөвшөөрөгдсөн практик юм.** “М” ХХК нь авсан зээлээ буцаагаад доллароор бүрэн төлөх ёстой байтал төгрөгөөр тооцон дутуу төлж, төлбөр бүрэн барагдуулаагүй байхад хариуцагч нь шийдвэр гүйцэтгэлийн

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:  
[https://shuukh.mn/single\\_case/11056?daterange=2026-01-01%20-%202026-06-02&id=3&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/11056?daterange=2026-01-01%20-%202026-06-02&id=3&court_cat=1&bb=1)



ажиллагааг дуусгавар болгож байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1.3, 107 дугаар зүйлийн 107.5, 113 дугаар зүйлийн 113.1, Арбитрын тухай хуулийн 48 дугаар зүйл 48.1 дахь хэсгүүдэд заасныг зөрчсөн ба ... хуулиар тодорхой зохицуулж өгсөн харилцааг илтэд буруу тайлбарлан хэрэглэсэн. ... “М” ХХК нь 12,425,206.3 ам.доллар мөн 856,570.33 еврог дутуу төлсөн. ...” гэж тодорхойлсон байна.

Хариуцагч Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “..Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гагцхүү Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулдаг. “Гадаадад оршин суугаа төлбөр авагчид төлбөрийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх газрын данснаас банкаар дамжуулан гадаад төлбөр тооцооны журмаар олгох, шилжүүлэх журам”-аар баталсан. Тус журмын 2.5-д “[Гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ёсны ханшаар тодорхойлно](#)” гэж зохицуулсан. Журмын энэхүү зохицуулалт Шүүхийг шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5 болон Иргэний хуулийн 217 дугаар зүйлийн 217.1 дэх хэсэгт заасанд тус тус нийцсэн. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа хууль зөрчөөгүй, гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрөөр тооцоолсон...” гэж маргажээ.

## ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүх:** “М” ХХК нь хүлээсэн үүргээ биелүүлэхдээ буюу төлбөрийг төлөхдөө банк хоорондын ханшийн эрсдэлийг хүлээх замаар үүргээ биелүүлэх ёстой гэж үзэхээр байна. Тодруулбал, гэрээний тал ам.долларын зээл авч, [гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд түүний хүлээх үүргийн хэмжээ монгол төгрөгийн ам.доллартой харьцах харьцаанаас шалтгаалан өссөн байх эрсдэлийг үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тал хариуцна](#). Иймд төлбөр авагчийн дансанд арбитрын шийдвэрт тухайлан заасан төлбөрийг буюу нийт 85,350,466.8 ам.доллар болон 856,570.33 евро орж ирснээр төлбөр төлөгч “М” ХХК-д холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болох ёстой гэж дүгнэх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө”, 113 дугаар зүйлийн 113.1-д “Төлбөр төлөгчөөс шүүхийн шийдвэрт заасан хөрөнгө, мөнгийг гаргуулснаар төлбөрийг биелүүлсэнд тооцно” гэж заасантай нийцнэ.
- 2. Давж заалдах шатны шүүх** анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ “... Монгол улсын нэгдэн орсон 1958 оны Нью-Йоркийн конвенцод гадаад улсын арбитрын шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны явцад үндэсний мөнгөн тэмдэгтээр төлөгдсөн төлбөрийг гадаад валют руу хөрвүүлэх ханшийг хэрхэн тооцох талаар тусгайлан зохицуулаагүй байна. Иймд уг асуудлыг Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх үндэслэлтэй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5 дахь хэсэгт гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр



гарсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тодорхойлно гэж заасан. Уг хэсгийн зохицуулалтын агуулга нь зөвхөн бэлэн мөнгөний төлбөртэй холбоотой харилцааг зохицуулахад чиглээгүй, ... гадаад валютаар төлсөн төлбөрийн ханшийг төлбөр төлсөн өдөр бүрийн ханшаар тооцохоор заасан гэж өргөтгөж тайлбарлах боломжгүй. ... Герман улсын Арбитрын институтын 2020.09.28-ны өдрийн [шийдвэр гарах үеийн байдлаар Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар](#) ам.доллар 2,854 төгрөг, евро 3,319 төгрөг байжээ. Энэ ханшийн талаар гаргасан хариуцагчийн тайлбарыг нэхэмжлэгч тал үгүйсгээгүй. Дээрх ханшаар тооцоход арбитрын шийдвэрт заасан төлбөр 85,350,466.8 ам.доллар нь 243,590,232,247 төгрөг, арбитрын зардал 856,570.33 евро нь 2,842,956,925 төгрөг, нийт 246,433,189,172 төгрөг болж байна. Харин төлбөр төлөгч нь 246,517,008,635 төгрөг төлсөн. Өөрөөр хэлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1 дэх хэсэгт зааснаар төлбөр төлөгч шүүхийн шийдвэрт заасан хөрөнгө, мөнгийг төлсөн тул төлбөрийг биелүүлсэнд тооцно. Иймд хариуцагч байгууллагын зүгээс төлбөр төлөгдсөн үндэслэлээр дээрх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон нь үндэслэлтэй. ... Ханшийн эрсдэлтэй холбоотой нэхэмжлэгч талын тайлбарыг хүлээн авахгүй боломжгүй. Энэ талаар анхан шатны шүүх [гэрээний тал ам.долларын зээл авч, гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд түүний хүлээх үүргийн хэмжээ монгол төгрөгийн ам.доллартой харьцах харьцаанаас шалтгаалан өссөн байх эрсдэлийг үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тал хариуцна гэж дүгнэсэн нь үндэслэлгүй.](#) ” гэж дүгнэсэн.

- 3. Хяналтын шатны шүүх:** Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журам, үүний дотор гадаад валютын ханшийг хэрхэн тооцож, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулж, төлбөрийг төлүүлэх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болсон эсэхтэй холбоотой хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс дараах дүгнэлтийг хийлээ:
- 4.** Арбитрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д “Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харьяалах шүүхэд өргөдөл гаргаснаар энэ хуулийн 48, 49 дүгээр зүйл болон Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцод заасан журмын дагуу арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэнэ.” гэж заасан. Уг конвенцын 1 дүгээр зүйлийн 1, 3 дугаар зүйлд тус тус зааснаар конвенцыг иргэн, хуулийн этгээдийн хооронд гарч болох маргааны талаарх бусад улсын нутаг дэвсгэрт гарсан арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд хэрэглэх, хэлэлцэн тохирогч улс бүр арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх шийдвэр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг өөрийн улсын хэрэг хянан шийдвэрлэх эрхийн хэм хэмжээг баримтлан конвенцод заасан нөхцөлөөр биелүүлэхээр байна. [Дээрх конвенцод гадаад улсын арбитрын шийдвэрийг гүйцэтгэхэд гадаад валютын ханшийг хэрхэн тооцох талаар нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй тул энэхүү маргаанд өөрийн улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх хэм хэмжээг хэрэглэн шийдвэрлэнэ.](#)
- 5.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1-д зааснаар төлбөр төлөгчөөс шүүхийн шийдвэрт заасан хөрөнгө, мөнгийг гаргуулснаар төлбөрийг биелүүлсэнд тооцох ба мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т “төлбөр



төлөгч гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрөө бүрэн төлсөн” бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцохоор заасан. Өөрөөр хэлбэл, Герман улсын Арбитрын институтын 2020.09.28-ны өдрийн шийдвэрт заасан нийт 85,350,466.8 ам.доллар, 856,570.33 евро бүрэн төлөгдсөн нөхцөлд төлбөр төлөгч төлбөрийг биелүүлсэн буюу төлбөрөө бүрэн төлсөн гэж үзэж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгоно. **Гагцхүү төлбөр төлөгчийг төлбөрөө бүрэн төлсөн гэж үзэхэд дээрх гадаад валютыг хөрвүүлэх ханшийг тооцох үе, цаг хугацааг тогтоосноор буюу төлбөрийг төлөх үеийн эсхүл гадаад улсын арбитрын шийдвэр гарсан өдөр, эсхүл арбитрын шийдвэрийг шүүхээр баталгаажуулснаар аль хугацаагаар тодорхойлохыг хуульд нийцүүлэн зөв тогтоох шаардлагатай.** (18)<sup>2</sup>

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5-д заасан “Гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тодорхойлно.” гэсэн нь **зөвхөн бэлэн мөнгөөр төлөгдсөн төлбөрт хамаарна гэж үзэх үндэслэлгүй.** Өөрөөр хэлбэл шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс мөнгийг бэлэн, бэлэн бус аль ч хэлбэрээр гаргуулсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэх газрын дансанд шилжүүлэх ажиллагаа болон төлбөрийг төлбөр авагчийн банкин дахь дансанд шилжүүлэх ажиллагаа хийгдэх боломжтой байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5-д заасан гадаад валютын ханшийг тодорхойлох ажиллагаа зөвхөн төлбөрийг бэлэн мөнгөөр гаргуулсан тохиолдолд хэрэгжинэ гэж үзэх үндэслэлгүй. Иймээс төлбөр төлөгч төлбөрийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлснөөс шалтгаалж, гадаад валютын ханшийг тооцох хугацааг өөр өөрөөр тодорхойлох боломжгүй. **Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хуульд заасны дагуу тодорхой хугацаа, үе шат, дарааллаар явагдах, уг ажиллагааны талаар талууд гомдол гаргах, гомдлыг шийдвэрлэх тусгайлсан журам үйлчилдэг зэрэг нөхцөл байдлын улмаас төлбөр төлөгч, төлбөр авагч хэн алинаас шалтгаалж, төлбөрийг төлөх хугацаа харилцан адилгүй байх боломжтой тул гадаад валютын ханшийг төлбөр төлсөн хугацаа тус бүрээр тодорхойлох нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд баримтлах зарчим болон нийтлэг шаардлагад нийцэхгүй.** Эдгээр үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчөөс гадаад валютаар төлөх төлбөрийг гаргуулж, мөнгийг олгохдоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5-д зааснаар гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тодорхойлох нь зүйтэй. (19)
7. Улмаар **гадаадын арбитрын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж, төлбөр төлөх гадаад валютын ханшийг тодорхойлох өдрийг арбитрын шийдвэрийг баталгаажуулсан шүүхийн шийдвэр гарсан өдрөөр тогтоох нь зүйтэй.** Арбитрын шийдвэр нь шүүхээр баталгаажуулж, гүйцэтгэх хуудас олгогдсоноор шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэх боломжтой болдог тул гадаад валютын ханшийг ийнхүү шүүгчийн захирамж гарсан 2023.04.27-ны өдрөөр тогтоох нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5-д нийцнэ. Иймээс нэхэмжлэлийн шаардлагыг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгохоор шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэв. (21)

---o0o---

<sup>2</sup> “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.